

# Гэрэл унтраахуй

Ленни  $3 \times 3$  хэмжээтэй хүснэгт болгон тавьсан гэрэлнүүдээр тоглох дуртай. Тоглоом эхлэхэд гэрэлнүүд бүгд асаалттай байна. Тэрээр аль нэг гэрлийг сонгон авч үйлдэл хийдэг ба ингэхэд сонгосон гэрэл мөн түүнтэй аль нэг талаараа хөрш гэрлүүдийн төлвийг эсрэгээр нь сольдог (асаалттай бол унтраах, унтраалттай бол асаах). Тэгвэл тоглоом эхэлснээс хойш Ленигийн гэрэл тус бүрийг хэд хэдэн удаа сонгосон нь мэдэгдэж байгаа бол яг одоо гэрлүүд ямар ямар төлөвтэй байгааг олно уу.

## Input

Гурван мөр болон гурван баганаас тогтох утгаараа 0-ээс багагүй 100-аас ихгүй 9 ширхэг тоо өгөгдөх ба  $i$  дэх мөрийн  $j$  дэх тоо нь  $i$  дэх мөрийн  $j$  дэх гэрэл хэдэн удаа дарагдсаныг илэрхийлнэ.

## Output

Гаралт нь гурван мөрөөс тогтох ба мөр бүр нь гурван тэмдэгт агуулна. Хэрэв  $i$  дэх мөрийн  $j$  дэх гэрэл асаалттай бол  $i$  дэх мөрийн  $j$  дэх утга "1" эсрэг тохиолдолд "0" байна.

## Example

### Input 1:

```
1 0 0
0 0 0
0 0 1
```

### Output 1:

```
001
010
100
```

### Input 2:

```
1 0 1
8 8 8
2 0 3
```

### Output 2:

```
010
011
100
```